

МАНСУУРУУЛАХ БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИСЫН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХЭД СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ

TRAINING INSTITUTION'S RESPONSIBILITY TO COMBAT ILLEGAL TRAFFICKING OF PSYCHOLOGICAL EFFECT OF SUBSTANCES AND NARCOTICS



Р.БАЯРМАГНАЙ

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн тагнуулын
тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн хошууч
BAYARMAGNAI R.

ass. Prof, Criminal Intelligence department, Police Institute,
Law Enforcement University, (Ph.D), Police major

Товч утга: Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй Монгол Улсын төрийн бодлого, цаашдын чиг хандлага. Түүнтэй тэмцэж буй төрийн тусгай албад түүний дотор Цагдаагийн байгууллагаас мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой хэрхэн тэмцэж буй болон түүнтэй тэмцэх алба хаагчдыг бэлтгэн гаргаж байгаа Хууль сахиулахын их сургуулийн сургалтын бодлого, зохицуулалт, сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн.

Abstract: The article is about Mongolian state policies for combating illegal trafficking of psychological effect of substances, narcotics and its further tendency. We analyzed on how police organization and other law enforcers combat illicit drug and Law Enforcement University training policy, regulations, curriculum and syllabus cause of preparing law enforcers in the university.

Key words: Narcotics, psychological influence of substances, UN, international agreement, bachelor curriculum.

Түлхүүр үгс: Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис, НҮБ, олон улсын гэрээ, бакалаврын хөтөлбөр.

Төрийн тулгуур бичиг баримт болох Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4 дэх хэсэгт “Монгол хүний эрүүл аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болхоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн”, 3.1.3.4-д “Цус ойртолтыг багасгах, архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна”, 3.4.4.3-д “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хяналт тавих хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний чадвахыг бэхжүүлнэ”, 3.4.4.4-д “Нийгэмд эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ”¹ гэж тус тус заасан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлогын үндэс мөн.

Монгол Улын Ерөнхийлөгч хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд онцгой анхаарал хандуулж “Өнөөдөр энэ аюултай тэмцэх

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Төрийн мэдээлэл, №10, 2010 он

үндэсний чадавх, сэрэмжлүүлж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ мэдээж туйлын хангалтгүй байна. Олон жил бор зүрхээрээ явж буй төрийн бус байгууллагууд байна... энэ ажлыг хөрөнгө мөнгөний “үлдэгдэлээр” явуулж байна... Улс үндэстний аюулгүй байдалд харш, манай нийгмийн сайн сайхан, ард иргэдийн маань амар амгалан амьдрахад аюул занал учруулдаг. Хүний өрх гэрийн аз жаргал, тэмүүлэлийг алга болгодог. Хүмүүсийн амьдралыг сүйтгэдэг тийм аюултай. Ийм учраас бид хар тамхины асуудал дээр хатуу бодлоготой байна”² гэсэн нь цаг үеэ олсон мэдэгдэл юм.

Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчдын улсын 5 дугаар зөвлөгөөн дээр Улсын Их хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж “Монгол Улсын хөгжилийн шинэ гарааны босгон дээр ирчихээд байна. Энэ жил дотоодын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 14 хувиар, оны эцэст 20 хувиар нэмэгдэх байдал ажиглагдаж байна... сайны зэрэгцээгээр саар зүйл гархыг үгүйсгэх аргагүй. Зэвсгийн наймаа, хар тамхины наймаа, хүний наймаа, мөнгө угаах гэсэн 4 төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд мөрдөн байцаах албаныхан цоо шинэ мэдээллээр хангагдаж, шинэ нөхцөлд ажиллах хэрэгтэй”³ гэж анхааруулсан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд баримтлах чиглэл юм.

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн түүхэн уламжлал орчин үеийн эрх зүйн орчин, энэ төрлийн гэмт хэрэг, түүнийг үйлдэгсдийн криминологи шинж, шалтгаан, нөхцөлийг авч үзсэний үр дүнд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох боломжтой юм.

Гэмт хэрэг нь аливаа нийгэмд зууралдсаар байдаг ч түүнтэй тэмцэх ажил төрийн үндсэн чиг үүргүүдийн нэг бөгөөд ихээхэн хэмжээний хөрөнгө, мөнгө зарцуулдаг. Тэгэхдээ гэмт хэргийг нэгэнт үйлдэгдсэн хойно араас нь асах их хөрөнгө, хүн, хүч хэрэгсэл зарцуулахын оронд уг гэмт хэргийг үйлдэхээс нь өмнө урьдчилан сэргийлэх нь хамгийн бага зардал гархаас гадна иргэдийг эд материал, сэтгэл санааны хохирол хямралаас хамгаалж, амгалан тайван аж төрөх олон талын ач холбогдолтой.⁴ Энэ талаар Ш.Л.Монтескье “Мэргэн хуульч гэмт хэрэг үйлдсэний төлөө заавал шийтгэхийн оронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд түлхүү анхаарах ёстой”⁵ гэж сургасан байдаг.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг нь ашиг олох зорилготой, үндэстэн дамнасан, зохион байгуулалтын шинжтэй болж байна. Мөн энэ төрлийн гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдал хүндэрч байгаа төдийгүй гэмт хэргийн гаралтын тоо, түүнд холбогдон шалгагдах хүмүүс байнга нэмэгдэж байгаа нь илрүүлсэн гэмт хэргээс харагдаж байгаа бөгөөд мансууруулах бодис хэрэглэгчдийг бий болгох үе шат явагдаж байна.

Иймд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийг илрүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтыг эрчимжүүлэх ажлыг шинэ түвшинд хүргэх шаардлагатай

² Ц.Элбэгдорж, Хар тамхитай холбоотой гэмт хэрэгтэнд өршөөл гэж үгүй, өнөөдөр сонин №053 /4517/, 2012.03.05

³ Хууль дээдлэх ёс сэтгүүл, №03 /34/, 2011 он

⁴ Б.Болдбаатар, Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдалаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, УБ., 2004, 9 дэх тал

⁵ Шарль Луи Монтескье, Хуулийн амин сүнс, “Мон судар” УБ., 2009, 231 дэх тал

байна.

Хууль сахиулахын их сургууль нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэгтэй шинжлэх ухааны үндэслэлтэй, гадаад улсын тэргүүн туршлагаас судалж, сургалтын үйл ажиллагаандаа зохих өөрчлөлтүүдийг тухай бүрт нь хийж байна. Жишээ нь, 2012 онд “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал”, 2013 онд “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогийн хэрэгжилт, чиг хандлага”, 2014 онд “Хууль сахиулахуйн инноваци” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж түүнээс гарсан санал, зөвлөмжийг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх сургалтанд ашиглаж байна.

Тус сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төв нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн талаар 2012 онд Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл судалгааны төвтэй хамтран “Хар тамхины гэмт явдлын шалтгаан нөхцөл” сэдвээр, 2013 онд Хууль зүйн яамны захиалгаар “Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага” сэдвээр криминологи судалгааг хийж гүйцэтгэсэн.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургууль нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийг мөрдөх сургалтандаа манай улсад мансууруулах төрлийн ургамал нэлээд тархацтай ургадаг тодорхой аймаг орон нутгуудыг байршил, төрөл, ангилалын талаар тодорхой сургалтуудыг зохион байгуулж байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглээр Олон улсын гэрээ, баримт бичгүүд болох НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай 1961 оны Нэгдсэн конвенци”⁶, “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” 1971 оны конвенци⁷, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенци”⁸, “Мансууруулах бодисын тухай” 1961 оны нэгдсэн конвенцид засвар, өөрчлөлт оруулах тухай 1972 оны протокол, “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг” НҮБ-ын 1988 оны конвенцуудын агуулгыг мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэхэд байнга хэрэглэгддэг угтвар бодис, түүхий эд, урвалуудын жагсаалтыг гаргаж тэдгээрийг хяналтанд авах асуудлыг олон улсын эрх зүйн үндсийг судалж мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, түүнээс олох ашиг орлогыг олон улсын хяналтанд авах, хууль бус эргэлттэй тэмцэх, хууль бус эргэлтээс олсон ашиг орлого, эд хөрөнгийг хураан авах, энэ төрлийн гэмт хэрэгтэй оновчтой тэмцэх боломжийг сургалтандаа бүрдүүлж ажиллаж байна.

ХСИС-ийн Цагдаагийн сургууль нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр тодорхой үе шаттайгаар судалгааны ажил, сургалтыг зохион байгуулж ирсэн билээ. Жишээ нь, Цагдаагийн сургуулийн Эрүүгийн тагнуулын тэнхим нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар мөрдөх арга зүйн талаар сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд үе

⁶ UN United Convention on narcotic drugs, 1961 – Монгол Улс 1990.12.06-нд нэгдэн орсон.

⁷ Энэ конвенцийг Монгол Улс 1999.04.22-нд соёрхон баталсан

⁸ Энэ конвенцид Монгол Улс 2001.01.25-нд нэгдэн орсон

шаттайгаар өөрчлөлтийг хийж байгаа бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мэргэжлийн алба хаагчидтай хамтарсан сургалтыг зохион байгуулсан нь сонсогч, оюутны лекц, семинарын хүрээнд олсон мэдлэгээ бататгахад түлхэц болсон.

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн дугаар А/78 Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн байтлах тухай, Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн дугаар А/174 нийтлэг шаардлага батлах тухай тушаалын дагуу Цагдаагийн сургуулийн харьяанд “Мөрдөх алба-хууль сахиулах ажил” (мөрдөгч) бакалаврын боловсролын хөтөлбөр, “Цагдаа-хууль сахиулах ажил” бакалаврын боловсролын хөтөлбөрийг боловсруулан цаашид эдгээр мэргэжлээр элсэлт авхаар бэлтгэж байна.

Дүгнэлт

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээний сайтуудад гарч буй мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн тухай мэдээлэл нь уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сэрэмжүүлэхээсээ илүүтэй бусдыг уриалан дуудсан, хэрэглэх аргыг нь сурталчилсан, зарим тохиолдолд хэрэглээний мэдлэг олгосон эсвэл нийгэмд батлагдаж, нотлогдоогүй мэдээллийг цацаж, айдас, хүйдэс төрүүлсэн шинж чанартай байна.

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн сургалтын хөтөлбөрт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх талаар бие даасан хичээл сургалт ордоггүй нь энэ гэмт хэргтэй тэмцэх алба хаагчдад хангалтгүй мэдлэг олгож байна гэж дүгнэж байна.

Санал

Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9.1.3 дугаар зүйлд: “Гүйцэтгэх ажлыг Цагдаагийн байгууллага гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гэдэг үгийн өмнө “урьдчилан сэргийлэх” гэж нэмж оруулах;

НҮБ-ын Зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц түүнийг дагалдан гарсан гурван протоколд тусгагдсан “хяналтан дор хүргэх”⁹, “шалгалтын худалдан авалт”¹⁰, “данс царцаах” аргуудыг Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23.3 дахь зүйлд нэмэлтээр оруулах;

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гадаад дотоодын сургалтуудыг цагдаагийн байгууллагын алба тус бүрээр нь сургалтад хамруулах;

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, даван, мэргэшүүлэх сургалтыг ХСИС-ийн Цагдаагийн сургуульд зохион байгуулж эхлэх;

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх бие даасан хичээлийг нэмж оруулах;

⁹ Хяналтан дор хүргэх гэдэг нь: гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын хяналт дор тусгай зөвшөөрлийн дагуу мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг тус улсын нутаг дэвсгэрийн хүрээнд шилжүүлэх, уг нутаг дэвсгэрт оруулах, гаргах эсвэл дамжин өнгөрүүлэх бололцоог хангахад чиглэгдсэн гүйцэтгэх ажлын арга хэмжээг хэлнэ. (Р.Б)

¹⁰ Хяналтын худалдан авалт гэдэг нь гүйцэтгэх ажлын эрх бүхий байгууллагаас мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг олж авахад чиглэгдсэн гүйцэтгэх ажлын арга хэмжээ бөгөөд түүнийг уг бодисыг борлуулах хамгийн дэлгэрсэн арга болох худалдах ажиллагааг баримтжуулахыг хэлнэ. (Р.Б)